БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2023 оны 07 дугаар сарын 29 өдөр

**ДҮҮРГИЙН СПОРТ ХОРООНЫ БАРИЛГЫН ДОТОР ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 7 дугаар сарын 24-ны өдөр　　　　Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| **1** | Төсөл боловсруулах үндэслэл | - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 7 дугаар сарын 07-ны 11 дүгээр тогтоол. |
| **2** | Байршил, эдэлбэр газрын хэмжээ | - Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо Хан-Уул дүүргийн спорт хорооны барилга |
| **3** | Зориулалт хүчин чадал | - Хан-Уул дүүргийн спорт хорооны барилгын засвар |
| **4** | Одоогийн байдал | Спорт хорооны барилгын дотор засвар:<br>- Спорт заал болон оффис өрөөнүүдийн хана, таазны будаг хуучирч муудсан, өнгө үзэмж муутай, модон шал хуучирч муудсан, сагсан бөмбөгийн шид хуучирсан, онооны самбар эвдэрсэн, спорт заалны хаалга болон оффис өрөөний хаалгануудыг шинээр солих шаардлагатай, Ариун цэврийн өрөөнүүд болон сауны цахилгаан, гэрэлтүүлэг ажилладаггүй, ариун цэврийн өрөөнүүдийн засварлах шаардлагатай хуучирч муудсан, хэрэглээний шаардлага хангахгүй болсон зэргээс шалтгаалан их засварын ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай. |
| **5** | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно. |
| **6** | Төслийн захиалагч | - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| **7** | Төсөл гүйцэтгэх байгууллага | - Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой. |
| **8** | Ажил гүйцэтгэх үе шат | - Талбайн судалгаа, хэмжилт хийх.<br>- Зураг төсөв боловсруулж батлуулах.<br>- Магадлал хийлгүүлэх. |

| | | |
|---|---|---|
| 9 | Иж бүрэн засварын ажилд тавигдах шаардлага | Ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэх, доор дурдсан хийгдэх ажлыг эрэмбийн дагуу, холбогдох хүмүүстэй зөвшилцөж төсөвт өртөгт багтах хэмжээгээр засварын ажлын зураг төсвийг боловсруулна.<br>Спорт заалны дотор засвар:<br>- Хана, таазны будаг хусаж, цэвэрлэн орчин үеийн загвар дизайн бүхий засалтайгаар төлөвлөх.<br>- Шүүгч болон тайлбарлагчийн суудаг хэсгийг стандартын дагуу засаж шинэчлэх.<br>- Хуучин модон шалыг хуулан, бетон тэгшилгээ хийж, агч модон шал шинээр төлөвлөх.<br>- Спорт заалны зориулалтын гэрэлтүүлэг шинээр төлөвлөх.<br>- Сагсан бөмбөгийн онооны самбар бүхий стандарт зөөвөрлөх боломжтой шид суурилуулах.<br>- Спорт заалны хаалга хаалгыг шинээр солихоор төлөвлөх<br>- Шалны хөвөөгөөр угсрагдсан банзан суудал хуучирч муудсан тул суудлын тоог нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж төлөвлөх.<br>Бусад өрөөнүүдийг засварлах:<br>- Ариун цэврийн өрөөнүүд болон сауны цахилгаан, гэрэлтүүлгийг стандартын дагуу аюулгүй, хэвийн ажиллагаатай болгох.<br>- Ариун цэврийн өрөөнүүдийн засварлах шаардлагатай хэсгийг засварлах, шаардлагатай тохиолдолд шинээр хийх.<br>- Бохир усны шугам болон агааржуулалтын хоолойнд үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд засварлаж, шинэчлэх.<br>- Цэвэрлэгээний өрөөг стандартын дагуу душ болгон иж бүрэн засварлах.<br>- Оффис өрөөний хаалгануудыг модон хаалгаар солихоор төлөвлөх.<br>- Бусад оффис өрөөнүүдийн хана таазыг шаардлагатай тохиолдолд будаж, засварлах.<br>- Засварын ажлуудыг хийхэд дагалдан гарах шаардлагатай засварын ажлуудыг хийх. |
| 10 | Төсөл боловсруулахад ашиглах материал | <u>**Монгол Улсын хуулиуд**</u><br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Бусад холбогдох хууль<br><u>**Төсөл хөтөлбөрүүд:**</u><br>- Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага<br><u>**Норм, нормативууд:**</u><br>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбд30-01-04/.<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /<u>БНбД</u> 3.01-06-90/.<br>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм.<br>- Бусад холбогдох норм, дүрэм. |
| 11 | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох. |

| | | |
|---|---|---|
| **12** | Онцгой нөхцөл | - Тус ажилд ашиглах материал сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол улсын стандартад нийцсэн материал байх<br>- Ажил эхлэх үед холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээллэнэ.<br>- Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах<br>- Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийг мөрдөн төлөвлөх. |

- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЛУВСАНЖАМЪЯН

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Л.УРАНЧИМЭГ